МЭДЭЭ · 2020 оны 2-р сарын 14

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨВ



Булган аймгийн прокурорын газрын прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан З.Хүслэн, аймгийн ерөнхий прокурорын туслах ажилтан Д.Энхбаяр нарын Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдөр тус газарт боллоо.

Тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигийн хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-д заасны дагуу ёс төртэйгээр зохион байгууллаа.



БУЛГАН АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3032